



МОНГОЛЫН ХҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар A/17

Улаанбаатар хот

Г Т.Даваасамбууд тэтгэмж олгох тухай Г

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Байгууллагын дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Төвийн Баримал керамекийн багш Т.Даваасамбуугийн эхнэр 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр амаржсан тул нэг удаагийн тэтгэмж олгосугай.
- Тэтгэмжээр олгох 100.000 /нэг зуун мянган/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Нягтлан бодогч /Х.Отгонбаяр/-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Д.УРАНБИЛЭГ



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 4/18

Улаанбаатар хот

Г X.Отгонбаяарт нягтлан бодох мэргэшсэн
эрхийн нэмэгдэл олгох тухай Г

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн нягтлан бодогч Хандрагчаагийн Отгонбаяарт 2020 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн нэмэгдлийг олгосугай.
2. Мэргэшсэн эрхийн нэмэгдлийг үндсэн цалингийн 15% /арван тав/ хувиар тооцож зохих хуулийн хүрээнд олгохыг Нягтлан бодогч /Х.Отгонбаяарт/ зөвшөөрсүгэй

ЗАХИРАЛ

Д.УРАНБИЛЭГ





МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 119

Улаанбаатар хот

Г С.Баярмаад тэтгэмж олгох тухай Г

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Байгууллагын дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.6.4 хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Төвийн архив, захидал харилцааны ажилтан С.Баярмаагийн ээж Ё.Туул нь удаан хугацаагаар өвдөж эмчлүүлэх зайлшгүй шаардлага гарсан тул үндсэн цалингийн 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгосугай.
- Мөнгөн тэтгэмжийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Няглан бодогч /Х.Отгонбаяр/-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ

Д.УРАНБИЛЭГ





МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 04 өдөр

Дугаар 8/20

Улаанбаатар хот

Г Архивын баримтад нэгдсэн тооллого хийх комисс байгуулах тухай Г

Архивын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 4.7.8, Нийслэлийн хэмжээнд төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг зохион байгуулах 3 дугаар ажлын хэсгийн “Илтгэх хуудас-ны 3.4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Архивын газраас 2019 оны 12 сарын 11-ний өдөр ирүүлсэн 02/719 дугаартай албан бичгийн дагуу “Архивын баримтад нэгдсэн тооллого хийх комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч

Дотоод хяналт, хуулийн зөвлөх: С.Дэлгэржаргал

Гишүүд:

Хүний нөөцийн ажилтан: Л.Атар

Сургалтын менежер: Б.Чулуунцэцэг

Архив бичиг хэргийн ажилтан: С.Баярмаа

Нярав: Н.Түвшинбаяр

Захирлын туслах: Б.Батчимэг

2. Энэхүү тушаалын 1 дүгээр зүйлд заасны дагуу архивын баримтад нэгдсэн тооллого хийх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийж, 2020 оны 08 сарын 14-ны өдрийн дотор “Захирлын зөвлөл”-ийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

ЗАХИРАЛ



Д.УРАНБИЛЭГ



МОНГОЛЫН ХҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 8/21

Улаанбаатар хот

Г Хэвлэмэл хуудас хүчингүйд тооцож устгах тухай Г

Монгол улсын Архивын тухай хуулийн 9.4.1 дэх заалт, Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар баталсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 7 дугаар зүйлийн 7.3.2.2, Засгийн газрын 2019 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтэц, тэдгээрийн орон тооны хязгаарыг батлах тухай” 100 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт болон албан хаагчдын буруутай үйл ажиллагаатай холбоотойгоор 2018-2019 оны хүчингүй болсон 15 ширхэг хэвлэмэл хуудсын жагсаалтыг хавсралтаар хүчингүйд тооцож устгасугай.
2. Хэвлэмэл хуудсыг нүдээр үзэж устгахыг Нягтлан бодогч Х.Отгонбаяр, Нярав н.Түвшинбаяр нарт даалгасугай.

ЗАХИРАЛ

Д.УРАНБИЛЭГ





МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 25 өдөр

Дугаар A/23

Улаанбаатар хот

Г Дотоод журам батлах тухай Г

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан “Хүүхдийн урлан бүтээх төвийн дүрэм”-ийн 3.6 дахь заалт, Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн 2020 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар “Төрийн албанд ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай “ зөвлөмж, 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн хамт олны хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн Хөдөлмөрийн дотоод журмыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Хөдөлмөрийн дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт багш, албан хаагчдад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналт, хуулийн зөвлөх /С.Дэлгэржаргал/, Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Л.Атар/, Сургалтын менежер /Б.Чулунцэцэг/, Нийгмийн ажилтан /Б.Энхцэцэг/ нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захирлын 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Д.УРАНБИЛЭГ



ХҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 8/24

Улаанбаатар хот

Г Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх тухай Г

Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, байгууллагын дотоод журмын 9 дүгээр зүйлийн 7. ё дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ахмадын баярыг тохиолдуулан төвөөс өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, хавсралтад заасны дагуу мөнгөн тэтгэмж олгосугай.
2. Мөнгөн тэтгэмж олгоход шаардагдах 1 400 000 /Нэг сая дөрвөн зуун мянган/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргахыг Нягтлан бодогч /Х.Отгонбаяр/-д зөвшөөрсүгэй.
3. Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Нийгмийн ажилтан /Б.Энхцэцэг/, Нярав /Н.Түвшинбаяр/ нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Д. УРАНБИЛЭГ





ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 18 өдөр


Дугаар 1/25

Улаанбаатар хот

Г Ш.Оюун-Эрдэнэд тэтгэмж олгох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Байгууллагын дотоод журмын 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Төвийн хийц бэлтгэгч Ш.Оюун-Эрдэнийн төрсөн дүү Ш.Бавуудорж 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр зуурдаар таалал төгсөж гачигдал гарсан тул тэтгэмж олгосугай.
- Тэтгэмжээр олгох 300,000 /гурван зуун мянга/ төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг Няглан бодогч /Х.Отгонбаяр/-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ 
Д.УРАНБИЛЭГ

УХ30172 9077499



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БУТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 28 өдөр

Дугаар A/26

Улаанбаатар хот

Г Хөрөнгө гаргах тухай Г

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Байгууллагын дотоод журмын 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн албан хаагчдад шаардлага хангасан ажлын хувцас олгосугай.
2. Ажлын хувцас олгох албан хаагчдын нэрсийг хавсралтаар баталсугай.
3. Ажлын хувцас авахад шаардагдах нийт 2,100,000 /хоёр сая нэг зуун мянга/ төгрөгийг нормын хувцас, зөвлөн эдлэлийн зардлаас гаргахыг Нягтлан бодогч /Х.Отгонбаяр/-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ

Д.УРАНБИЛЭГ





МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 8/27

Улаанбаатар хот


Г

Хөрөнгө бүртгэх тухай

Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

- Төвд хандив тусlamжаар ирсэн нийт 5.107.500 /таван сая нэг зуун долоон мянга таван зуун/ мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг үндсэн хөрөнгийн данс бүртгэлдээ бүртгэж авахыг Нягтлан бодогч /Х.Отгонбаяр/-т зөвшөөрсүгэй.
- Хавсралтанд заасан нийт 5.107.500 /таван сая нэг зуун долоон мянга таван зуун/ мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьж ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл /Б.Ганбаатар/-т үүрэг болгосугай.





МОНГОЛЫН ХҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 8/28

Улаанбаатар хот

Г Тооллого явуулах тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1 дэх заалт, Байгууллагын дотоод журмын 12 дугаар зүйлийн 12.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн үндсэн хөрөнгө, хангамжийн материалыг тоолох 2020 оны жилийн эцсийн тооллогын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:


Д.Ганбаатар	Аж ахуйн ажилтан
Б.Энхцэцэг	Нийгмийн ажилтан
С.Байгалмаа	Мэдээлэл технологийн ажилтан
Г.Бурмаа	Галлерейн эрхлэгч
С.Чимгээ	Лаборант

2. Үндсэн хөрөнгө, хангамжийн материалын тооллогыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулахыг ажлын хэсгийн бүрэлдхүүнд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Л.Атар/-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Д.УРАНБИЛЭГ





МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 5/31

Улаанбаатар хот

Г Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт
шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4 дэх заалт,
Засгийн газрын 2020 оны 226 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны
A/1320 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төвийн багш, албан хаагчид 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийг хүртэл гэрээсээ цахимаар ажилласугай.
2. Ажлын байрандаа зайлшгүй ажиллах шаардлагатай захиргаа, аж ахуйн албан хаагчид, ээлжийн жижүүр, сантехникийн слесарь нарт халдварт хамгааллын дэглэмийг чанд сахиж ажиллахыг үүрэг болгосугай.
3. Бүх нийтийн бэлэн байдлын үед ажлын байрандаа ажиллах албан хаагчдын нэрсийг нэгдүгээр, цахимаар ажиллах тур журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
4. Албан хаагчдын цахимаар ажиллах тур журмын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн мэргэжилтэн /Л.Атар/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Дэд захирал /Ч.Отгонгэрэл/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Д.УРАНБИЛЭГ

УХ30172 9077499